



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 13 өдөр

Дугаар A/616

Улаанбаатар хот

### Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 1999 оны А/155 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хан-ул дүүргийн 2 дугаар хороо, 19 үйлчилгээний төвийн шуудангийн 36 дугаар салбар 111,3 м<sup>2</sup> талбайтай, нийт 28,388,915.00 (хорин найман сая гурван зуун наян найман мянга есөн зуун арван тав) төгрөгийн үнэ бүхий барилгыг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Ерөнхий нягтлан бодогч (Т.Оюунтуул)-д зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу данс бүртгэлдээ бүртгэн, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч (Т.Оюунтуул)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

*В. Ааргулаа*

В.ОЮУМАА